

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны <u>12</u> сарын <u>30</u> едер



Улаанбаатар хот

Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1. Онцгой байдлын албаны сургалтын бодлогыг нэгдүгээр, сургалт, бэлтгэлийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөөг хоёрдугаар, бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг зохион байгуулах журмыг гуравдугаар, бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг шалгаж үнэлэх зааврыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- 2. Батлагдсан сургалтын бодлого, хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөө, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
- 3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.
- 4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/309 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ

АРИУНБУЯН



Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Онцгой байдлын байгууллагын сургалтын бодлого нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, Хүний нөөцийн бодлогод үндэслэн алба хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд баримтлах үндсэн баримт бичиг байна.

Хоёр. Сургалтын бодлогын зорилго, баримтлах зарчим

2.1. Сургалтын бодлогын зорилго

2.1.1. Онцгой байдлын байгууллага нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд алба хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх, өргөсөн тангарагтаа үнэнч хариуцлагатай байх хандлагыг төлөвшүүлэх, байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллахад оршино.

2.2. Сургалтын бодлогын зарчим

- а/ Шинжлэх ухааны үндэслэлтэй байх;
- б/ Тодорхой зорилго чиглэлтэй байх;
- в/ Гамшгаас хамгаалах үндсэн үүргийг биелүүлэхэд бэлтгэгдсэн байх;
- г/ Болзошгүй гамшгийн цагийн байдалд ойртуулсан (бодитой, уян хатан) байх;
 - д/ Алба хаагчдын (бүтээлч) санаачилга, бие даасан байдалд тулгуурлах;
- е/ Дэс дараалалтай, иж бүрэн (цогцолбор), хөнгөнөөс хүнд рүү шилжиж байх;
 - д/ Идэвхтэй, тасралтгүй, оновчтой байх;
 - е/ Байнга шинэчлэгдэн боловсорч байх зарчмыг баримтална.

Гурав. Сургалтын тогтолцоо, сургалтын бодлогын үндсэн чиглэл

3.1. Сургалтын бодлогын үндсэн чиглэл;

3.1.1. Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн сургалт, хөгжлийн талаар дараах үндсэн чиглэлийг баримтална:

а/ Хүний нөөцийн сургалт, хөгжлийн урт, богино хугацааны бодлого,

төлөвлөлт, чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх;

б/ Онцгой байдлын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн дээд /бакалавр/ боловсролтой, мэдлэг, ур чадвартай алба хаагчийг гадаад, дотоодын мэргэжлийн сургалтын байгууллагад захиалгаар сургаж бэлтгэх, сургалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

в/ Гадаад, дотоодын их, дээд сургуулийн бакалавр, магистр, адъюнктурт, доктор, удирдах ажилтныг бэлтгэх сургалтад алба хаагчдыг суралцуулж,

хөгжүүлэх;

г/ Гадаад, дотоодын тэтгэлэгт болон мэргэшүүлэх сургалтад алба

хаагчийг суралцуулж, боловсролын зэргийг нь дээшлүүлж, хөгжүүлэх;

д/ Байгууллагын болон алба хаагчийн сургалтын хэрэгцээг харгалзан алба хаагчийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх давтан болон мэргэшүүлэх, ур

чадварын сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулах;

е/ Алба хаагчийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх бүтээлч санаачилгыг

дэмжиж, тэдний өөрийгөө хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

ж/ Алба хаагчийн сургалт, хөгжлийн тогтолцоо, агуулга, арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга шинэчилж, боловсронгуй болгох.

3.2. Онцгой байдлын албаны сургалтын тогтолцоо нь дараах сургалтын төрлүүдээс бүрдэнэ;

3.2.1. Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт;

3.2.2. Алба хаагчдыг мэргэшүүлэх болон албан тушаалтны давтан сургалт;

3.2.3. Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт;

3.2.1. Алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох сургалт нь;

3.2.1.1. Төв байгууллагын захиалгаар мэргэжлийн их сургуульд "Боловсролын тухай хууль", "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомж, сургалтын стандарт, хөтөлбөрийн дагуу өдрийн, гаригийн, эчнээ хэлбэрээр тогтоосон хугацаагаар зохион байгуулна.

3.2.1.2. Алба хаагчдаас бакалаврын боловсролтой алба хаагчийг байгууллагын захиалгаар Онцгой байдал, гамшгаас хамгаалах чиглэлээр гадаад,

дотоодын их, дээд сургууль, академид бэлтгэнэ.

- 3.2.1.3. Бакалаврын хөтөлбөрийн эчнээ хэлбэрийн сургалтад Онцгой байдлын албанд 3 ба түүнээс дээш жил үр бүтээлтэй ажиллаж байгаа алба хаагчийг харьяа байгууллагын саналыг харгалзан тус тус элсүүлэн суралцуулна. Энэ тохиолдолд Захиргааны удирдлагын газар холбогдох бичиг баримтыг үндэслэн суралцуулна.
- 3.2.1.4. Гадаад, дотоодын их, дээд сургууль, академи, магистрын сургалтад Онцгой байдлын албанд 5, түүнээс дээш жил ажилласан, цаашид дэвшин дээшлэх, удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэгдсэн алба хаагчийг ажлын үр дүн, харьяа байгууллагын саналыг харгалзан элсүүлэн суралцуулна.
- 3.2.1.5. Захиргааны удирдлагын газар нь холбогдох сургалтын байгууллагуудтай хамтран гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах чиглэлээр тулгамдсан асуудлын чиглэлээр хийх шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, чиглэлийг боловсруулан судалгааны ажлыг захиалгаар гүйцэтгүүлэх гэрээг магистр, адъюнктурт, докторт элссэн алба хаагчтай байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангана.
 - 3.2.2. Алба хаагчдыг мэргэшүүлэх болон албан тушаалтны давтан сургалт;
- 3.2.2.1. Онцгой байдлын байгууллагын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу гадаад, дотоодод давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтад хамруулах болон төрийн ба төрийн бус байгууллага, их, дээд сургууль, академитай хамтарч сургалтыг зохион байгуулах ажлыг хариуцсан нэгж, албан тушаалтан, хариуцан танхимийн, дадлагын, зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

3.2.2.2. Давтан сургалт нь алба хаагчийн нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн чадамжийг дээшлүүлж, дадал, чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгдэх ба сургалтын агуулгын 60 ба түүнээс дээш хувь нь алба хаагчийг

дадлагажуулж, чадваржуулах сургалт байна.

3.2.2.3. Мэргэшүүлэх сургалт нь алба хаагчдын ажлын арга, тактикийн мэдлэг, ур чадварын түвшинг нь дээшлүүлэх, албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшлийн чадамж олгох болон түвшинг нь дээшлүүлэх сургалт байна.

3.2.2.4. Ур чадварын сургалт нь алба хаагчдын ур чадварыг ахиулах, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх чиглэгдэх ба ажлын 3-5 хоногийн

хугацаагаар зохион байгуулагдана. Сургалтын агуулга нь дадлагажуулах, чадваржуулах сургалт байна.

3.2.2.5. Онцгой байдлын албанд анх орсон болон туршилтын хугацаагаар ажиллаж байгаа иргэнийг тусгай төлөвлөгөөний дагуу ажлын үр дүнг харгалзан 1 сараас доошгүй хугацааны чадавхжуулах сургалтад хамруулна.

3.2.2.6. Алба хаагчдын давтан болон мэргэшүүлэх сургалтыг тодорхой орон зайнаас мэдээлэл, харилцааны хэрэгслүүдээр дамжуулан зайны сургалтын хэлбэрээр /утас, ном, сурах бичиг, гарын авлага, цахим харилцаа, видео г.м/ зохион байгуулж болно.

3.2.2.7. Нутаг дэвсгэрийн онцлог, ажил, үүргийн чиглэл, нөхцөл байдлаас хамааран бүсчилсэн, хээрийн дадлага хосолсон хэлбэрийн сургалтыг зохион байгуулж болно.

3.2.3. Бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн сургалт

3.2.3.1. Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгаас хамгаалах чадахыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, Цэргийн нийтлэг дүрмүүд, албанд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүд;

3.2.3.2. Гамшиг, аюулт, үзэгдэл, ослын тухай ерөнхий ойлголт, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүсэж болох хүндрэл бэрхшээл, даван туулах, аврах,

хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээний талаар;

3.2.3.3. Онцгой байдлын албанд ашиглагдаж буй аврах, гал унтраах, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тактик техникийн үзүүлэлт, ашиглалтыг эзэмшсэн байх;

3.2.3.4. Орос, Англи хэлний зохих мэдлэгийг эзэмшиж, хөтөлбөрт заагдсан сэдвээр нарийвчлан судална.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Захиргааны удирдлагын газар нь байгууллагын сургалтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, Онцгой байдлын албаны хүний нөөцийн сургалт, хөгжлийн статеги, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулан, хэрэгжилтыг хангуулж хяналт тавина.

4.2. Байгууллагын хэмжээний алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг Онцгой байдлын ерөнхий газар, өдөр тутмын сургалт, бүсчилсэн сургалт, ажлын байранд дадлагажуулах сургалтуудыг төв, орон нутгийн Онцгой

байдлын байгууллага зохион байгуулна.

Тав. Онцгой байдлын албаны сургалтын бодлого

5.1.Сургалтын бодлогыг тодорхойлох үндсэн чиглэлийн хүрээнд үндсэн бичиг баримт болох сургалт бэлтгэлийн хөтөлбөр, ерөнхий журам, зохион байгуулах заавар, төлөвлөгөө, стандарт, шалгаж үнэлэх заавар, норм, нормативуудыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

5.1.1. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлээр эзэмшсэн мэдлэг, боловсрол, мэргэжил, ур чадвар, сэтгэл зүйн түвшин, бие бялдрын

бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж мөрдүүлнэ;

5.1.2. Сургалт, бэлтгэлийг зохион байгуулах удирдамжийг тухайн жилд байгууллагын өмнө тавигдсан зорилт, гамшгийн нөхцөл байдлын дүн мэдээг үндэслэн тухай бүр шинэчлэн тодотгоно.

5.1.3. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх зааврыг боловсруулан мөрдөж, сургалт бэлтгэлийн үр дүнд жил бүр дүн шинжилгээ хийнэ.

5.1.4. Алба хаагчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, ахиулах ажлыг журмын дагуу зохион байгуулна.

5.

5.2. Алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, тэднийг тасралтгүй хөгжүүлэх, аливаа бүтээлч санаачилгыг дэмжих үндсэн чиглэлийн хүрээнд сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалт, бэлтгэлийн тогтолцоог шинэчлэх, мэргэжлийн боловсрол олгох, мэргэшүүлэх, давтан сургалтын чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.2.1. Сургалтыг гадаад дотоодын их, дээд сургууль, холбогдох

мэргэжлийн байгууллагыг түшиглэн зохион байгуулна.

5.2.2. Онцгой байдлын албаны сургалт бэлтгэлийн тогтолцоог байгууллагын өөрчлөлт, хөгжлийн бодлого, хэрэгцээ шаардлагатай уялдуулан боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2.3. Онцгой байдлын байгууллагын бүтцийн нэгж нь алба хаагчдыг мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд дэмжих, шатлан

дэвших зарчмыг баримтлах;

Хүрэх үр дүн. Албан хаагч-хувь хүний мэдлэг, чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг, чадвар, туршлага болгон хөгжүүлснээр суралцагч байгууллага болон хөгжинө.

Ингэснээр албаны бэлтгэл, бэлэн байдал, зохион байгуулалт сайжирч, гамшгийн нөхцөл байдал, үүссэн цагийн байдлыг зөв үнэлэн шийдвэр гаргах,

албан үүрэг гүйцэтгэх чадавх дээшилнэ.

5.3. Гамшгаас хамгаалах болон албаны сургалт бэлтгэлийн сургагч багш нарыг бэлтгэх, чадавхжуулах үндсэн чиглэлийн хүрээнд Онцгой байдлын албанд олон жил ажилласан, гамшгаас хамгаалах онолын болон практик дадлага туршлагатай алба хаагчдыг сонгон шалгаруулж, сургагч багш бэлтгэх, чадавхжуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

5.3.1. Онцгой байдлын байгууллагын сургалтын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан, олон жил ажилласан туршлагатай алба хаагчдыг тусгай

сургалтад хамруулан багшлах эрхийн үнэмлэхтэй олгоно.

5.3.2. Тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэж, чадавхжуулах

арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.3.3. Алба хаагчдын сургалтын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, стандартуудыг хэрэгжүүлэх, сургалтын заавар, зөвлөмж боловсруулах, санал өгөх, заах арга зүйн сургалтыг зохион байгуулах, зөвлөмжөөр хангах, сургалтын талаар дэвшилтэт арга технологийг судлах, нэвтрүүлэх, сургалтын үр дүнг тооцох, сургалтын асуудал хариуцсан нэгж, алба хаагчдын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, сургалтын чиглэлээр онол практикийн хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах чиг үүрэг бүхий "Сургалт, заах арга зүйн зөвлөл"-ийг ажиллуулна.

Хүрэх үр дүн. Сургалт бэлтгэлийг зохион байгуулах бүрэлдэхүүний заах арга зүйн мэдлэг, ур чадвар сайжирч, шинэлэг арга техник ашиглах идэвх санаачилга өрнөж, сургалт бэлтгэлийг шинжлэх ухаанч, онол практикт тулгуурлан,

тодорхой үр дүнтэй явуулах үндэс тавигдана.

5.4. Сургалтын нэгдсэн төв, бүсийн болон зайн сургалтын танхим байгуулж, материаллаг баазыг бэхжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд алба хаагчдыг бүх талаар сурч хөгжих боломжийг хангах сургалтын гарын авлага, техник хэрэгсэл, номын сан, зайны сургалтын танхим болон нэгдсэн сургалтын төвийг байгуулж, материаллаг баазыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.4.1. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага сургалт бэлтгэл явуулах орчин үеийн техник хэрэгслээр үе шаттайгаар хангах төлөвлөгөө

боловсруулан хэрэгжүүлнэ.

5.4.2. сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд бүхий хотхон, талбай, болон төв. орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс анги,

байгууллагуудад биеийн тамир-чийрэгжүүлэлтийн танхим, сэтгэл зүйн өрөө, сургалтын танхимыг байгуулж сургалтын орчин бүрдүүлнэ.

5.4.3. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага бүсийн төвүүдэд гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, сургалтын нэгдсэн төв, зайн цахим сургалтын танхим, номын санг байгуулж ашиглалтад оруулна.

5.4.4. сургалт бэлтгэлийн үндсэн хичээлүүдийн сурах бичиг, гарын авлага, цахим сургалтын материал, мэргэжлийн сорилын эмхэтгэл зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар боловсруулан гаргана.

Хүрэх үр дүн. Сургалт бэлтгэлийн материаллаг бааз сайжирч, шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлагаар хангагдсанаар бие бүрэлдэхүүний бие дааж суралцах боломж, идэвх санаачлаг нэмэгдэн сургалт бэлтгэлийн үр өгөөж дээшлэн, байгууллагадаа хандах хандлага сайжирна.

5.5. Сургалтын нэгдсэн сан бүрдүүлж ашиглах үндсэн чиглэлийн хүрээнд байгууллагын хүний нөөцийн мэдээллийн сантай уялдсан сургалтын мэдээллийн нэгдсэн сан, цахим орчин бүрдүүлж алба хаагч бүр хүртээмжтэйгээр ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.5.1 байгууллагын хүний нөөцийн мэдээллийн сантай уялдсан

сургалтын мэдээллийн санг бүрдүүлж ашиглалтад оруулна.

5.5.2. сургалтын мэдээллийн санг сургуулийн жилийн удирдамж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулан хөгжүүлж, алба хаагч бүрт нээлттэй хуртээмжтэйгээр ажиллуулна.

5.5.3. сургалтын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан, сургалт, заах арга зүйн зөвлөлийн гишүүд мэдээллийн технологийн өндөр мэдлэг эзэмшиж, сургалтын талаар гадаад, дотоодын сургууль, байгууллагын дэвшилтэт арга технологийг судлах, нэвтрүүлэх арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлнэ.

5.5.4. сургалт бэлтгэлийн үр дүнг мэдээллийн санг ашиглан гаргаж, сургалт бэлтгэлийг сайжруулах, боловсронгуй болгох санал дүгнэлтийг

боловсруулна.

Хүрэх үр дүн. Байгууллагын хүний нөөцийн бодлого болон сургалтын бодлогын хэрэгжилт нэгдсэн мэдээллийн сантай уялдсанаар алба хаагчдыг сургаж хөгжүүлэх явц шударга, нээлттэй болно. Сургалтын бүртгэл, тооцоо тодорхой болж, статистик үзүүлэлт бүхий үр дүн нь байгууллагын хөгжилд хувь нэмэр оруулах хөшүүрэг болно.

Зургаа. Сургалтын бодлогын хэрэгжилт

6.1. Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулж, мэргэжлийн удирдлага арга зүйн зөвлөмжөөр хангаж, нэгдсэн дүнг гаргаж, үр дүнг тооцон ажиллана.

6.2. Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж уялдуулан


алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна.

6.3. Онцгой байдлын байгууллагын салбар нэгжүүд үндсэн чиг үүргийн хүрээнд сургалтын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж үр дүнгээ Онцгой байдлын байгууллагын сургалтын асуудал хариуцсан нэгж тайлагнана.

6.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, түүний салбар нэгжүүд сургалтын бодлого, хөтөлбөрийн хэрэгжүүлэх үндсэн хэрэглэгч бөгөөд үйл

ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

6.5. Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг даргын зөвлөлд тайлагнана. (Тайланд Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгж дүн шинжилгээ хийнэ).



сургалт, бэлтгэлийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөө

Нэг. Нийтлэг үндэслэл

Сургалтын чанарыг сайжруулах, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүнд сургуулийн жилд мэргэжлийн ур чадвар, албаны бэлтгэлийг сайжруулахад чиглэсэн төрөл мэргэжлээр цаг сэдвээр нь авч хэрэгжүүлнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүнд сургуулийн жилд аюулт үзэгдэл, ослын тухай ойлголт, түүнтэй хэрхэн тэмцэх, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээний талаар мэдлэг олгох, чадварт тулгуурлан авах арга хэмжээг дадлагаар эзэмшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд алба хаагчдыг сургаж, хөгжүүлэх тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Сургалт бэлтгэлийн зарчим, шаардлага

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1.1. Хууль, эрх зүйн хүрээнд явагдсан байх: Сургалт, бэлтгэлийг албанд

мөрдөж буй хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд явуулна.

3.1.2. Шинжлэх ухааны үндэслэлтэй байх: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг судалгаа, тооцоонд үндэслэн байгууллагын зорилтын хүрээнд шинжлэх ухаанчаар боловсруулж, орчин үеийн техник, технологийг өргөнөөр ашиглана.

3.1.3. Бодитой байх: Сургалт, бэлтгэлийг байгууллагын хөгжил, бие бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдал, цаг үеийн нөхцөл байдал, төсөв хөрөнгийн

боломжид тулгуурлан явуулна.

3.1.4. Уян хатан байх: Сургалт, бэлтгэлийг бие бүрэлдэхүүний ажил мэргэжлийн онцлог, албан тушаалын зэрэглэл, төрөл мэргэжлийн онцлогийг харгалзан ялгавартайгаар, төрөл бүрийн арга, хэлбэрээр явуулна.

3.1.5. Түүхэн тогтолцоотой байх: Сургалт, бэлтгэлийн үр дүн, ололтыг

цаашдын бодлого, зорилттой уялдуулан төгөлдөржүүлнэ.

3.2. Сургалт, бэлтгэлийн шаардлага

3.2.1. Бие бүрэлдэхүүн нь эрхэлж буй албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг хангаж, энэхүү хөтөлбөрт заагдсан албаны мэдлэг, дадлага, чадварыг эзэмшсэн байна.

3.2.2. Бие бүрэлдэхүүний албаны мэдлэг, чадварыг дараах шаардлагын

тувшинд унэлнэ. Үүнд:

- Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгаас хамгаалах чадахыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр, Цэргийн нийтлэг дүрмүүд, албанд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүд;

-Гамшиг, аюулт, үзэгдэл, ослын тухай ерөнхий ойлголт, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүсэж болох хүндрэл бэрхшээл, даван туулах, аврах,

хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээний талаар;

8.

-Онцгой байдлын албанд ашиглагдаж буй аврах, гал унтраах, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тактик техникийн үзүүлэлт, ашиглалтыг эзэмшсэн байх:

-Англи хэлний зохих мэдлэгийг эзэмшиж, хөтөлбөрт заагдсан сэдвээр нарийвчлан судална.

3.2.3. Дадлагажсан байх шаардлага

-Эзэмшсэн мэдлэгийг албаны үйл ажиллагаанд үр дүнтэй хэрэгжүүлэхэд дадлагажсан байна.

3.2.4. Чадваржсан байх шаардлага

-мэргэжлийн ур чадварыг цагийн байдлын ямар ч нөхцөлд бие даан болон бүлгээр бүрэн хэрэгжүүлэх чадвар эзэмшсэн байна.

3.3. Сургалт, бэлтгэлийн зохион байгуулалт

3.3.1. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нь Сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөг батлах бөгөөд сар бүр хичээлийн хуваарийг хариуцсан мэргэжилтэн /Сургалтын алба/ гаргаж мөрдүүлнэ.

3.3.2. бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн явцад албаны бэлтгэл, мэргэжлийн бэлтгэл, тусгай бэлтгэлийн хичээлүүдээр тест бөглүүлэх, асуулт хариулт, штабын дадлага, дасгал боловсруулах, норматив биелүүлэх зэрэг төрөл бүрийн арга хэлбэрээр сар бүр шалгаж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагчийн тушаалаар улирал тутам явуулна.

3.3.3. хичээлийн удирдагч, багш нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор офицеруудын заах арга зүйн бэлтгэлийг хичээлийн жилийн эхэнд 6-аас доошгүй

цагийн хугацаатай сурган зааварлах, үзүүлэх хэлбэрээр зохион байгуулна.

3.3.4. онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан хөтөлбөрийг үндэслэн тухай орон нутгийн ажлын ачаалал, төрөл мэргэжлийг бүтцийн нэгжүүд тухай жилийн сургалт, бэлтгэлийг зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж зохион байгуулна.

3.3.5. сургалтыг офицер, ахлагч, үйлчилгээний ажилчид гэсэн төрлөөр 7

хоногийн нэг өдрөөр явуулна.

3.3.6. ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэл хичээлийн хөтөлбөрийг ялгавартайгаар зохион байгуулах ба сургалтыг бүтцийн нэгжийн сургалт хариуцсан мэргэжилтэн, офицерууд тухайн хичээлийн хөтөлбөрт тусгагдсан сэдвийг бие дааж судалж хичээлийг явуулна.

3.3.7. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх 120 дугаар ангийн тамирчид цэргийн хэргийн сургалтыг 30 хувь, мэргэжлийн сургалтыг 70 хувь

байхаар тооцож явуулна.

3.3.8. нийт бие бүрэлдэхүүнд гадаад хэлний анхан болон дунд түвшний сургалтыг зохион байгуулах ба багшлах бүрэлдэхүүнийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдаас сонгож явуулах, эсвэл гадны байгууллагын мэргэжлийн хүнээр хичээлийг зохион байгуулж явуулна.

3.3.9. офицер бүрэлдэхүүний сургалтыг бүтцийн нэгжийн сургалт хариуцсан

нэгж, албан тушаалтан төлөвлөж зохион байгуулна.

3.3.10. цэргийн биеийн тамирыг гимнастик, саадын зурвас, гардан тулаан, усны сэлэлт, цана, хөнгөн атлетик, хурдавчилсан хөдөлгөөн үйлдэх, авиралт, буулт, спорт тоглоомын төрлүүдээр нэгжийн гүйцэтгэх үүргийн онцлогт тохируулан Цэргийн биеийн тамирын заавар /ЦБТЗ-18/-ын дагуу зохион байгуулна.

3.3.11. биеийн тамирын сургалтыг явуулах материаллаг бааз, сургалтын техник хэрэгсэл, талбайг дотоод нөөц бололцоогоо ашиглан зохион байгуулна. Спортын ажлыг бие бүрэлдэхүүний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглүүлэхээс гадна мэргэжлийн спортын цогцолбор норм биелүүлэхэд чиглүүлэн дугуйлан хичээллүүлнэ.

9

3.3.12. "цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ын "Биеийн зохистой харьцаа", "Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн норматив"-ыг хангах зорилгоор алба хаагчдад тохирсон дугуйлан хичээллүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэн бие бялдрын түвшин тогтоох сорил улирал бүр авч, дүнг нэгтгэн зөвлөмж өгч ажиллана.

Дөрөв. Сургалт, бэлтгэлийн хөтөлбөрийн төрөл

4.1. Сургалт, бэлтгэлийн хөтөлбөр нь:

-Офицер бүрэлдэхүүний

-Ахлагч бүрэлдэхүүний

- Эрэн хайх, аврах нохойн
- -Улсын нөөцийн салбарын

- Гэрээт ажилтны гэсэн төрөлтэй байна.

4.1.1. офицер сургалтын хөтөлбөр нь хууль эрх зүйн болон мэдлэг олгох, албанд мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврыг судлуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах арга хэмжээг удирдан зохион байгуулах, бэлэн байдлыг хангах, хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

4.1.2. ахлагч бүрэлдэхүүний сургалтын хөтөлбөр нь хууль эрх зүйн болон мэдлэг олгох, албанд мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврыг судлуулах, гамшиг, аюулт үзэгдэл ослын үеийн гарах шалтгаан, гарах үр дагавар авч хэрэгжүүлэх арга

хэмжээний мэдлэг олгоход чиглэгдэнэ.

албан үүргээ гүйцэтгэх үеийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр, сэтгэл зүйн хувьд бэлтгэх, тогтвортой байдлыг хангах, бие бялдрыг нь

хөгжүүлэх техник эзэмших дадлага, чадвар олгоход чиглэнэ.

4.1.3. төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад эрэн хайх, аврах чиглэлээр төрөл мэргэжлийн албаны нохойг сургах, сургалтад хамрагдсан алба хаагчдыг сургаж бэлтгэх, мэргэшсэн чадварлаг алба хаагчдыг давтан сургаж бэлтгэх, мэргэшсэн чадварлаг алба хаагчдыг бий болгоход чиглэгдэнэ.

4.1.4. Улсын нөөцийн салбарын сургалтаар хууль эрх зүйн болон Улсын нөөцийн бараа материалыг хүлээн авах, хадгалах, захиран зарцуулах талаар

судалж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгоход чиглэнэ.

4.1.5. гэрээт ажилчдад хууль эрх зүй, хөдөлмөрийн гэрээ, ажил олгогч, ажилтны эрх үүрэг болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, харилцааны чиглэлээр бүтцийн нэгжийн сургалт хариуцсан албан тушаалтан төлөвлөж явуулна.

Тав. Алба хаагч, албан тушаалтны үүрэг

5.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нь сурах нөхцөл боломжоор хангах, сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн сургалтын танхим, номын сан, гадаад хэлний танхимыг байгуулж, сургалтын орчин бүрдүүлэх;

5.2. Сургалт хариуцсан нэгж, анги, салбарууд албан тушаалтан нь

хичээлийн журнал, хичээлийн конспект хэрэглэгдэхүүнтэй байна.

5.3. Хичээл заах багш нь хичээлийг туршлагад суурилсан аргаар харилцан

ярилцах, жишээ авах зэргээр үр дүнтэй аргуудаар явуулна.

5.4. Сургалт явуулах томилгоожсон алба хаагч нь хичээлийн явцад асуулт асуух, даалгавар өгөх, үр дүнг тооцох зорилгоор хичээлийн явцын оноо өгөх шалгалтын дүнд нэмж оруулах;

5.5. Алба хаагч нь мэргэжил, мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг тасралтгүй дээшлүүлэх, өөрөө сурч, хөгжих талаар санаачлагатай байна.

5.6. Алба хаагч нь мэдлэг, ур чадвараа бие даан суралцах болон хичээлийн хөтөлбөр, цаг сэдвийн цагийг зохих журмын дагуу хангана.

5.7. Алба хаагч бүр мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд анхаарч хичээлийн дэвтэр, сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлнэ.

5.8. Алба хаагч нь бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлтэй, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлт, биеийн зохистой харьцааг хангах;

Зургаа. Сургалтын үр дүнг үнэлж дүгнэх

6.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь зохион байгуулагдсан сургалтын үр дүнг өөрөө үнэлж, дүгнэхээс гадна Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж дүнг нэгдсэн гаргаж, үр дүнг тооцон ажиллана.

6.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын сургалт, бэлтгэлийн талаар улирал, жилийн тайланг бичиж Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгжид

ирүүлнэ.

6.3. Тайланд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, алба хаагчдын хичээлийн оролцоо, идэвх, мэдлэг, ур чадварын түвшингийн ахиц, сургалтыг шинэлэг арга хэлбэр, заагдсан хичээлүүдээр авсан шалгалтын нэгдсэн дүн, жилийн мөн үетэй харьцуулж гарсан ахиц, дэвшил, цаашид анхаарах асуудлыг фото зураг болон графикаар дэлгэрэнгүй тусгаж, холбогдох судалгааны материалыг хавсаргана.



БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЦАГ, СЭДВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Хичээлийн хөтөлбөрийн цагийн тооцоо

		Хич	ээл явуул	ах хэлбэр,	цаг
Nº	Хичээлийн төрөл	Онол	Бие даалт	Дадлага	Ний
1.	Офицер бүрэлдэхүүний албаны бэлтгэл хичээл	19	27	-	46
2.	Офицер бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэл хичээл	75	64	-	146
3.	Ахлагч бүрэлдэхүүний албаны бэлтгэл	32	18	11	61
4.	Жолооч нарын мэргэжлийн бэлтгэл хичээл	110	33	35	172
5.	Аврагч-гал сөнөөгч мэргэжлийн бэлтгэл хичээлийн хөтөлбөр	44	21	12	77
6.	Эрэн хайх, аврах анги, салбарын аврагч нарын мэргэжлийн бэлтгэл	86	+	80	166
7.	Холбоочин аврагчдын мэргэжлийн бэлтгэл хичээлийн хөтөлбөр	26	8	8	42
8.	Химичин аврагчдын мэргэжлийн бэлтгэл хичээл	44	+	62	106
9.	Аврагч тэсэлгээчний мэргэжлийн бэлтгэл хичээлийн хөтөлбөр	21	+	52	73
10.	Агаарын ажиллагааны салбарын аврагч нарын мэргэжлийн бэлтгэл	62	+	181	666
11.	Уул уурхайн аврагч мэргэжлийн бэлтгэл хичээлийн хөтөлбөр	23	+	85	108
12.	Англи хэл	34	27	36	107
13.	Жагсаалын бэлтгэл	+	+	33	33
14.	Бие бялдрын бэлтгэл	+	+	80	80
15.	Сэтгэл зүйн бэлтгэл	33	+	34	67
16.	Хүн эмнэлгийн бэлтгэл	46	+	34	80
17.	Эрүүл мэндийн бэлтгэл	23	+	7	30
18.	Эрэн хайх, аврах нохойн сургалт	+	+	582	582
19.	Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн нярав, гэрээт ажилчдын хичээлийн хөтөлбөр	33	25	+	58
20	Гэрээт ажилтны хичээл	13	13		26
	Нийт цаг	708	211	1334	2253

ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЛБАНЫ БЭЛТГЭЛ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

,	V		Явуулах хэлбэр,		
д/д	лесииХ	Хичээлийн нэр	Лекц	Бие даалт	Бүх цаг
		Сэдэв 1. Хууль, эрх зүй			New Jersey
1.	Хичээл 1	Монгол Улсын Үндсэн хууль	1	1	2
2.	Хичээл 2	Терийн албаны тухай хууль	1	1	2
3.	Хичээл 3	Гамшгаас хамгаалах тухай хууль	1	1	2
4.	Хичээл 4	Галын аюулгүй байдлын тухай хууль	1	1	2
5.	Хичээл 5	Улсын нөөцийн тухай хууль /холбогдох албан тушаалтан судлах/	1	1	2
6.	Хичээл 6	Цэргийн албаны тухай хууль	1	1	2
7.	Хичээл 7	Авлигын эсрэг хууль /холбогдох албан тушаалтан судлах/		2	2
8.	Хичээл 8	Төрийн болон албаны нууцын тухай хууль	1	1	2

12

9.	Хичээл 9	Зөрчлийн тухай хууль /холбогдох албан тушаалтан судлах/	1	1	2
10.	Хичээл 10	Төсвийн тухай хууль /холбогдох албан тушаалтан судлах/	1	1	2
11.	Хичээл 11	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /холбогдох албан тушаалтан судлах/	1	1	2
12.	Хичээл 12	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /холбогдох албан тушаалтан судлах/	1	1	2
	With the second	Бүгд	11	13	24
	C	эдэв 2. Дүрэм журам бусад эрх зүйн баримт	бичиг		
1.	Хичээл 1	Төрийн үйлчилгээний алба хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам /Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол/	1	1	2
2.	Хичээл 2	Төрийн албан хаагчид шагнал олгох журам /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол/	1	1	2
3.	Хичээл 3	Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол/	1	1	2
4.	Хичээл 4	Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар тогтоол/	1	1	2
5.	Хичээл 5	Онцгой байдлын байгууллагад алба хаах журам /Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 105 дугаар тушаал/	1	1	2
6.	Хичээл 6	Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам /Монгол Улсын зайд, ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалын хавсралт/	1	1	2
7.	Хичээл 7	Цэргийн нийтлэг дүрмүүд	1	5	6
3.	Хичээл 8	Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм	1	1	2
).	2 песьих	"Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэлийн маягт" бөглөх заавар /холбогдох албан тушаалтан судлах/	1	3	4
		Бүгд	9	15	24
11311		Нийт цаг	19	27	46

ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭРГЭЖЛИЙН БЭЛТГЭЛ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

		Явуулах хэлбэр, ца			
д/д	Бүлэг сэдэв	Сэдэв	Лекц	Бие даалт	Бүх цаг
	Сэд	эв 1. Гамшгаас хамгаалах менежментийн тог	толцос)	
1.	Хичээл 1	Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо	2	2	4

2.	Хичээл 2	Гамшгаас хамгаалах удирдлага, зохио байгуулалт, менежмент	1	2	3
3.	Хичээл 3		2	4	6
		Бүгд	5	6	13
		Сэдэв 2. Гамшгаас хамгаалах үйл ажилла	гаа		
4.	Хичээл 1	Гамшгаас хамгаалах төлөвлөлт	1	1	2
		Гамшгийн голомтод эрэн хайх аврах	,	-	
5.	Хичээл 2	ажиллагааны зохион байгуулалт	1	1	2
6.	Хичээл 3	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг түүнд шилжүүлэх журам	1	1	2
7.	Хичээл 4	Гамшиг, ослын үед тандалтын ажиллагааг зохион байгуулах		1	2
8.	Хичээл 5	Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах /шийдвэр гаргалт/	2	1	3
9.	Хичээл 6	Шадар сайдын 2017 оны 75-р тушаал Мэргэжлийн ангийн дүрэм	1	1	2
10.	. Хичээл 7	Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам /Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт/	1	1	2
11.	8 леечиХ	Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам /Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт/	1	1	2
12.	9 песечих	Эрсдэлийн менежментийн тухай ойлголт /Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар/	1	1	2
		Бүгд	10	9	19
		Сэдэв 3. Эрэн хайх, аврах ажиллагаа			1
13.	1 песих	Онцгой байдлын байгууллагын эрэн хайх, аврах нэгжид тавих шаардлага	1	1	2
14.	Хичээл 2	Уснаас эрэн хайх аврах ажиллагааны журам	1	1	2
15.	Хичээл 3	Эрэн хайх аврах ажиллагааны стандарт	1	1	2
16.	Хичээл 4	Нурангиас эрэн хайх, аврах ажиллагаа	1	1	2
17.	Хичээл 5	Уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа	1	1	2
18.	Хичээл 6	Онцгой байдлын байгууллагын уурхайн аврах ажиллагааны хувцас, хэрэглэлийн техникийн шаардлага /холбоедох албан тушаалтан судлах/	2	1	3
19.	Хичээл 7	Аюулт үзэгдэл, ослын тухай ойлголт	2	1	3
20.	Хичээл 8	Эрэн хайх, аврах ажиллагаанд нисдэг тэрэг	2	2	4
	741.1007.0	ашиглах нь		2000	
		Бүгд	11	9	20
		Сэдэв 4. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллаг	aa		
21.	Хичээл 1	Гал түймрийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	1	1	2
22.	Хичээл 2	Галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон норм, дүрэм	1	1	2
23.	Хичээл 3	Гал түймрийн Улсын хяналтын дүрэм, Гамшгаас хамгаалах Улсын хяналтын дүрэм	1	1	2
24.	Хичээл 4	Гал түймэр унтраах дүрэм /холбогдох албан тушаалтан судлах/	2	1	3
25.	Хичээл 5	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа	2	1	3
26.	Хичээл 6	Хорт хий утаанаас хамгаалах дүрэм /холбогдох албан тушаалтан судлах/	2	1	3
		Бүгд	9	6	15
	Сэдэв 5	. Ой, хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллага	a		
27.	Хичээл 1	Ой, хээрийн түймрийн гарах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс	1	1	2

28.	Хичээл 2	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажиллагаа	1	1	2
		Бүгд	2	2	4
		Сэдэв 5. Холбооны бэлтгэл		***	
29.	Хичээл 1	Байршил тогтоогч GPS –ын ажиллах журам	1	2	3
30.	Хичээл 2	Радио холбоо зохион байгуулах арга	1	1	2
31.	Хичээл 3	Радио станцын ашиглалт	1	1	2
		Бугд	3	4	7
	Сэдэв 6.	Цацраг, хими, биологийн өвчний үед хэрэгжү /Мэргэжлийн байгууллагаас оруулах хичээ	17	рга зам	
32.	Хичээл 1	Цацрагийн ослын үеийн үед авах хариу арга хэмжээ, удирдлага зохицуулалт /холбогдох албан тушаалтан судлах/	2	2	4
33.	Хичээл 2	Химийн хортой болон аюултай бодисын осол, ослын үед авах хариу арга хэмжээ, удирдлага зохион байгуулалт /холбогдох албан тушаалтан судлах/	2	2	4
34.	Хичээл 3	Хүн, малын гоц халдварт өвчин дэгдсэн үед авах хариу арга хэмжээ, удирдлага зохицуулалт	2	2	4
145		Бугд	6	6	12
	Сэдэі	в 7. Баримт бичиг боловсруулалт, албан хэрэ	г хөтл	элт	
35.	Хичээл 1	Монгол бичиг	10	10	20
36.	Хичээл 2	Албан бичгийн стандарт, ангилал, баримт бичигт тавигдах шаардлагын хангах	1		1
		and the comment of the complete contract of the contract of th			
37.	Хичээл 3	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах	1		1
37 . 38 .	Хичээл 3 Хичээл 4	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний	1		1
		Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах		10	
		Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал	1	10	1
38.		Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бүгд	1	10	1
38.	Хичээл 4	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бүгд Сэдэв 8. Тусгай бэлтгэл	1 13		1 23 5 2
38. 39. 40.	Хичээл 4 Хичээл 1	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бугд Сэдэв 8. Тусгай бэлтгэл Байр зүйн зураг түүний тухай ойлголт	1 13 4	1	1 23 5
39. 40. 41.	Хичээл 4 Хичээл 1 Хичээл 2	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бүгд Сэдэв 8. Тусгай бэлтгэл Байр зүйн зураг түүний тухай ойлголт Зураггүйгээр газар орон дээр зүг чиг олох	1 13 4 1	1	1 23 5 2
	Хичээл 4 Хичээл 1 Хичээл 2 Хичээл 3	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бүгд Сэдэв 8. Тусгай бэлтгэл Байр зүйн зураг түүний тухай ойлголт Зураггүйгээр газар орон дээр зүг чиг олох Тактикийн тэмдэглэгээ Стрессээс гарах арга зам замууд, стресст	1 13 4 1 1	1 1 1	1 23 5 2 2
39. 40. 41. 42.	Хичээл 4 Хичээл 1 Хичээл 2 Хичээл 3 Хичээл 4	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бүгд Сэдэв 8. Тусгай бэлтгэл Байр зүйн зураг түүний тухай ойлголт Зураггүйгээр газар орон дээр зүг чиг олох Тактикийн тэмдэглэгээ Стрессээс гарах арга зам замууд, стресст орохгүй байх аргууд Гамшгийн голомтод ажиллаж буй	1 13 4 1 1 2	1 1 1 1	1 23 5 2 2 2
39. 40. 41. 42.	Хичээл 4 Хичээл 1 Хичээл 2 Хичээл 3 Хичээл 4 Хичээл 5	Албанд хөтлөгдөх баримт бичгүүд, түүний бүрдлийг хангах Удирдлагын баримт бичгийн ангилал Бүгд Сэдэв 8. Тусгай бэлтгэл Байр зүйн зураг түүний тухай ойлголт Зураггүйгээр газар орон дээр зүг чиг олох Тактикийн тэмдэглэгээ Стрессээс гарах арга зам замууд, стресст орохгүй байх аргууд Гамшгийн голомтод ажиллаж буй бүрэлдэхүүний сэтгэл онцлог Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн	1 13 4 1 1 2 2	1 1 1 1	1 23 5 2 2 3 3 3

15

АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЛБАНЫ БЭЛТГЭЛ ӨӨЛӨТӨХ НЙИКСЕРИХ

				Явуулах	хэлбэр, ц	цаг
д/д	Бүлэг сэдэг	Сэдэв	Лекц	Бие даалт	Дадлага	Бүх цаг
		Сэдэв 1. Хууль				
1.	Хичээл 1	Монгол Улсын Үндсэн хууль	2	1		3
2.	Хичээл 2	Гамшгаас хамгаалах тухай хууль	2	1		3
3.	Хичээл 3	Төрийн албаны тухай хууль	2	1		3
4.	Хичээл 4	Галын аюулгүй байдлын тухай хууль	2	1		3
		Бүгд	8	4		12
		Сэдэв 2. Дүрэм журам				
8.	Хичээл 1	Цэргийн нийтлэг дүрэм	2			2
9.	Хичээл 2	Онцгой байдлын байгууллагад алба хаах журам /Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 105 дугаар тушаал/	1			1
10	Хичээл 3	Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм	1			1
11.	Хичээл 4	Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам /Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар тогтоол/	1			1
12.	Хичээл 5	Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны журам	1			1
13.	Хичээл 6	Гал түймэр унтраах дүрэм				
14.	Хичээл 7	Уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны журам	1			1
15.	8 песьиХ	Хорт хий утаанаас хамгаалах дүрэм	1			1
16.	9 лесииХ	Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам	1			1
		Бүгд	10			10
		Сэдэв 3. Ой, хээрийн түймэр унтраа	ах онцл	ОГ		
21.	Хичээл 1	Ой, хээрийн түймрийн гарах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс	1	1		2
		Бүгд	1	1		2
		Сэдэв 4. Холбооны бэлтгэл	1			1941
22.	Хичээл 1	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага сургуулийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ	1	1		1
26.	Хичээл 2	Радио холбооны тухай ерөнхий ойлголт	1	1	1	1
27.	Хичээл 3	Байршил тогтоох систем, GPS -ын ажиллах журам	1	1	1	1
		Бүгд	3	3	2	6
		Сэдэв 7. Гал түймэр				
28.	V MO 3-3-U	Гал түймрийн тухай ойлголт /Хүндрэл бэрхшээл/	1	1		2
29.	Хичээп 2	Гал түймэр унтраах хэрэгсэл түүнийг ашиглах	1	1	1	2
		Бүгд	2	2	1	4
		Сэдэв 8. Эрэн хайх, аврах ажилл	агаа			
80.	VMA:4411	Цацраг идэвхт бодис алдагдах үеийн ажиллагаа	1	1	1	3

		Нийт цаг	32	18	11	61
		Бүгд	7	7	7	21
36.	Хичээл 7	Байгалийн гаралтай гамшгаас эрэн хайх, аврах ажиллагаа	1	1	1	3
35.	Хичээл 6	Техникийн холбогдолтой ослоос аврах ажиллагаа	1	1	1	3
34.	Хичээл 5	Нурангиас эрэн хайх, аврах ажиллагаа	1	1	1	3
33.	Хичээл 4	Уснаас эрэн хайх, аврах ажиллагаа	1	1	1	3
32.	Хичээл 3	Уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа	1	1	1	3
31.	Хичээл 2	Химийн хорт бодис алдагдах үеийн ажиллагаа	1	1	1	3

ЖОЛООЧИЙН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ӨӨЛӨӨӨ ӨӨЛӨӨР

				Явуулах	хэлбэр, ца	г
д/д	Хичээл	Хичээлийн нэр	Лекц	Бие даалт	Дадлага	Бүл цаг
		Сэдэв 1. Дүрэм журам				
1.	Хичээл 1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм	4	1		5
2.	Хичээл 2	Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах тусгай тоноглол бүхий автомашинд тавигдах. Ерөнхий шаардлага /2019.10.23 A/317/	1	1		2
3.	Хичээл 3	Галын техник, галын гадна шат техникийн ерөнхий шаардлага	2	1	2	3
4.	Хичээл 4	Гал түймэр унтраах дүрэм /2016.05.16/	4	1		5
		Бүгд	11	4	2	15
		Сэдэв 2. Гал унтраах автомашин техн	ик хэр:	эгсэл		
5.	Хичээл 1	Үндсэн албаны автомашины төрөл, ангилал, үүрэг зориулалт, ТТӨ	3	3	2	8
6.	Хичээл 2	Тусгай албаны албаны автомашины төрөл, ангилал, үүрэг зориулалт, ТТӨ	4	4	2	10
7.	Хичээл 3	Туслах албаны автомашины төрөл, ангилал, үүрэг зориулалт, ТТӨ	4	4	2	10
		Бүгд	11	11	6	28
	Сэ,	дэв 3. Аврах зориулалтын автомашин т	гехник	хэрэгсэл	п	
8.	1 песьих	Аврах ажлын зориулалтын автомашины төрөл, ангилал, үүрэг зориулалт, ТТӨ	2	2	2	6
9.	Хичээл 2	Тусгай зориулалтын автомашины төрөл, ангилал, үүрэг зориулалт, ТТӨ	4	2	4	8
10.	8 леерих	Туслах зориулалтын автомашины төрөл, ангилал, үүрэг зориулалт, ТТӨ	2	2	2	6
		Бүгд	8	6	8	18
		Сэдэв 4. Тусгай зориулалтын авто	машин			
11.	Хичээл 1	АРС 14у, ДДА 3б авто машинуудын төрөл, зориулалт бүтэц, ажиллах зарчим, хүчин чадал	4	2	2	8
12.	Хичээл 2	Тээврийн хэрэгслийн ашиглалт	4	2		6
13.	Хичээл 3	Гал унтраах багаж хэрэгслийн тактик техник үзүүлэлт, зориулалт, ашиглалт	6	2		6

14.	Хичээл 4	Хүнд машин механизмын зориулалт ажиллах хүчин чадал, тактик техникийн өгөгдөхүүн		2		6
15.	Хичээл 5	Тусгай зориулалтын авто машинд хийгдэх техник үйлчилгээ	6	2	2	10
		Бүгд	30	12	4	40
		Сэдэв 5. Ус соруулагч /Мото	помп/			
16.	Хичээл 1	Ус соруулагч /Мотопомп/-ны төрөл зориулалт, бүтэц зохион байгуулалт	1			1
10.	Хичээл 2	Ус соруулагч /Мотопомп/-ны ажиллах зарчим	1		1	2
		Бүгд	2		1	3
		Сэдэв 6. Хөдөлгүүрийн сис	тем			
	Хичээл 1	Тоормосны систем, хүч дамжуулах механизм, жолооны механизм	1			1
17.	Хичээл 2	Дотоод шаталтын хөдөлгүүр, хөргөлтийн систем, гэрэлтүүлэх хэрэгсэл	1			1
		Бугд	2			
			Ga I			2
C	эдэв 7. Замі	ын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөд	-	хамгаал	ал аюул	-
С	эдэв 7. Замі	ын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөд ажиллагаа	-	хамгаал	ал аюул	-
С	Хичээл 1	ын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөд ажиллагаа ЗХТХ, ЭХ, ЗХАБТХ зэрэг хуулийн холбогдох зүйл заалт	елмер	хамгаал	ал аюул	-
С		ын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөд ажиллагаа ЗХТХ, ЭХ, ЗХАБТХ зэрэг хуулийн холбогдох зүйл заалт Замын хөдөлгөөний дүрэм	өлмөр	хамгаал	ал аюул	гүй
	Хичээл 1	ын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөд ажиллагаа ЗХТХ, ЭХ, ЗХАБТХ зэрэг хуулийн холбогдох зүйл заалт Замын хөдөлгөөний дүрэм Гал түймэр унтраах, эрэн хайх аврах ажиллагааны дуудлагын үед ирж буцах аюулгүй ажиллагаа	елмер	хамгаал		гүй 1
6	Хичээл 1 Хичээл 2	ын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөд ажиллагаа ЗХТХ, ЭХ, ЗХАБТХ зэрэг хуулийн холбогдох зүйл заалт Замын хөдөлгөөний дүрэм Гал түймэр унтраах, эрэн хайх аврах ажиллагааны дуудлагын үед ирж	елмер 1 1	хамгаал		1 3
12.	Хичээл 2	Нэрвэгдэгчийн биеийн байдал, гэмтлийн зэргийг тодорхойлох аргууд, Хөлдөлтийн үед үзүүлэх эмнэлгийн анхны тусламж, осгох	4	2	2
13.	Хичээл 3	Амин үзүүлэлтийг хэмжих арга зүй: Дарагдсан хам шинжийн үед үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	4	2	2
44	Хичээл 4	Бумба гич, тавих арга зүй: Мэргэжлээс шалтгаалах өвчний тухай ойлголт, урьдчилан сэргийлэлт	4	2	2
14.		The state of the s			
14.	Хичээл 5	Халдварт өвчин зооноз, байгалийн гоц халдварт өвчин: Шүлхий, боом, тарваган тахал,бруцеллёзын үед авах арга хэмжээ урьдчилан сэргийлэлт	4	2	2

		эв 4. Гэмтлийн үед үзүүлэх эмнэлгийн а га хийх аргачлал, нэрвэгдэгчийг зөөж тэ			
16.	Хичээл 1	Үе мөчдийн тасралт: Ясны хугаралтын үед үзүүлэх эмнэлгийн анхны тусламж	4	2	2
17.	Хичээл 2	Ясны гэмтэл: гэмтлийн мултралын үед үзүүлэх анхны тусламж үзүүлэх	4	2	2
18.	Хичээл З	Аюулгүй тарилгын тухай ойлголт: Аюулгүй хайрцгийг хэрэглэх, устгах, ариун зүү тариуртай харьцах арга зүй, эмийг туншил, флаконоос соруулах аргачлал Тарилга хийх арга, аргачлал арьсан доторх, арьсан дор, булчин тариа хийх, хураагуур судсанд тарилга хийх, шингэн дуслаар хийх үйлдлийн дараалалтай танилцах	4	2	2
19.	Хичээл 4	Цусны бүлэг тодорхойлох: Халуун, хүйтэн жин тавих аргачлал, Нэрвэгдэгсдийг зөөж тээвэрлэх ажиллагааны үндэс	4	2	2
20.	Хичээл 5	Гэмтэгсдийг зөөж тээвэрлэх зарчим, анхны тусламж үзүүлэх үеийн халдвар хамгааллын дэглэм, нэрвэгдэгчийг гарын доорх материал ашиглан өвчтөнийг тээврийн хэрэгслээр зөөвөрлөх	4	2	2
Бүгд			20	10	10
Нийт			80	46	34

ТУСГАЙ БЭЛТГЭЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

д/д	Хичээл	Хичээлийн нэр	Сургалтын хэлбэр, цаг			
μи			Лекц	Дадлага	Бүгд	
		Сэдэв 1. Өвчнөөс сэргийлэх ар	ra			
1.	Хичээл 1	Эрүүл мэндийн боловсрол олгох арга зүй?	1		1	
2.	Хичээл 2	Ариун материалтай харьцах арга зүй?	1		1	
Бүгд			2		2	
		Сэдэв 2. Эрүүл, зөв хооллолт				
3.	Хичээл 1	Багаар ажиллах арга зүй?			1	
4.	Хичээл 2	Үйлдлээ тайлбарлахын ач холбогдол?	1			
5.	Хичээл 3	Уламжлалт хоол хүнсний бүтээгдэхүүний хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, улиралдаа уялдуулан хооллох	1		1	
6.	Хичээл 4	Хоол хүнсний талаарх уламжлалт болон орчин үеийн хандлага	1		1	
Бүгд			3	BEET BEET BEET	3	
		Сэдэв 3. Хөдөлгөөн эрүүл мэнд				
7.	Хичээл 1	Дасгал хөдөлгөөн хийсний ач тус хүний биед хэрхэн нөлөөлөх	1		1	
8.	Хичээл 2	Дасгал хийх / ажлын байрны дасгал/	1	1	2	
Бугд			2	1	3	
		Сэдэв 4. Хорт зуршлын хор хөнөө	л			
9.	Хичээл 1	Архины хэрэглээ, хор хөнөөл	2		2	
10.	Хичээл 2	Тамхины хэрэглээ, хор хөнөөл				
		Бүгд	2		2	

	Нийт цаг			7	30
			1		1
21.	Хичээл 2	Халдварт шар, салхин цэцэг, улаанууд өвчнөөс сэргийлэх	1		1
20.	Хичээл 1	Гараа хэрхэн зөв угаах арга			
		Сэдэв 8. Эрүүл хүүхэд			
		Бүгд	6	6	12
19.	Хичээл 1	Эмнэлгийн анхны тусламж хэрхэн үзүүлэх арга, техник	6	6	12
		Сэдэв 7. Эмнэлгийн анхны тусла	Ж		
		2		2	
18.	Хичээл 2	Хүн, малын халдварт өвчний тухай ойлголт, сэргийлэх арга зам	1		1
17.	Хичээл 1	Хүнээс хүнд халдварладаг өвчний хүндрэл, сэргийлэх арга	1		1
		Сэдэв 6. Халдварт өвчнөөс сэргий	хепі		
		5		5	
16.	Хичээл 5	Цусны даралт ихсэх өвчин, урьдчилан сэргийлэлт	1		1
15.	Хичээл 4	Таргалалт ба 2-р хэлбэрийн чихрийн шижин өвчний тархалт хүчин зүйлс сэргийлэлт	1		1
14.	Хичээл 3	Бөөр ялгаруулах эрхтний өвчлөл эрсдэлт хүчин зүйлс	1		1
13.	Хичээл 2	Ходоод гэдэсний замын эрхтний хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлс	1		1
12.	Хичээл 1	Зүрх судасны өвчний хоол тэжээлийн байдлын эрсдэлт хүчин зүйлс	1		1

ЭРЭН ХАЙХ, АВРАХ НОХОЙН СУРГАЛТЫН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

д/д	Хичээл Хичээлийн нэр	200 100	Яву	Явуулах хэлбэр, цаг		
		Лекц	Дадлага	Бүх		
		Сэдэв 1. Эрэн хайх бэлтгэл		10 III - III - III		
1.	Хичээл 1	Гадаад цочруулагчид дасгах		20	20	
2.	Хичээл 2	Газар оронд эрэн хайх		52	52	
3.	Хичээл 3	Нурангид эрэн хайх		52	52	
4.	Хичээл 4	Уснаас эрэн хайх		50	50	
5.	Хичээл 5	Цаснаас эрэн хайх		48	48	
6.	Хичээл 6	Нохойн дуулгавартай байдлын дасгал		32	32	
7.	Хичээл 7	Нохой биеэ хянах эвслийн дасгал		32	32	
		Бүгд		286	286	
		Сэдэв 2. Нохойн сургалт бэлтгэл				
8.	Хичээл 1	Гадаад цочруулагчид дасгах		30	30	
9.	Хичээл 2	Нохойн дуулгавартай байдлын дасгал		38	38	
10.	Хичээл 3	Нохойн биеэ хянах, эвслийн дасгал		36	36	
11.	Хичээл 4	Сургагчид өгөх эерэг дохиог батжуулах		12	12	
12.	Хичээл 5	Тарваганы үнэрт дасгах		18	18	
13.	Хичээл 6	Тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх		82	82	
14.	Хичээл 7	Ачаа, тээшинд үзлэг шалгалт хийх		80	80	
15.	Хичээл 8	Ачаа, тээшинд үзлэг шалгалт хийх		-	-	
		Бүгд		296	296	
		Нийт цаг		582	582	

УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАРЫН НЯРАВ, ЭНГИЙН АЖИЛЧДЫН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

			Явуулах хэлбэр цаг			
д/д	Хичээл	Хичээлийн нэр	Лекц	Бие даалт	Бүх ца	
		Сэдэв 1. Хууль, эрх зүй				
1.	Хичээл 1	Хөдөлмөрийн тухай хууль	1	1	2	
2.	Хичээл 2	Гамшгаас хамгаалах тухай хууль	1	1	2	
3.	Хичээл 3	Улсын нөөцийн тухай хууль	1	1	2	
4.	Хичээл 4	Төрийн болон албаны нууцын тухай хууль	1	1	2	
5.	Хичээл 5	Галын аюулгүй байдлын тухай хууль	1	1	2	
6.	Хичээл 6	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	1	1	2	
7.	Хичээл 7	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай	1	1	2	
8.	8 песьиХ	Засгийн газрын 199 тогтоол /2008 он/	1	1	2	
9.	Хичээл 9	Засгийн газрын 364 тогтоол /2018 он/	1	1	2	
10.	Хичээл 10	Онцгой байдлын ерөнхий газрын 224 тушаал /2008 он/	1	1	2	
		Бүгд	10	10	20	
		Сэдэв 2. Дүрэм журам				
11.	Хичээл 1	Онцгой байдлын байгууллагын дүрэм, журам, заавар	1	1	2	
12.	Хичээл 2	Улсын нөөцөөс бараа материал захиран зарцуулах нөхөн бүрдүүлэх журам	1	1	2	
13.	Хичээл 3	Бараа материалыг хадгалах, сэлгэн шинэчлэх журам	1	1	2	
14.	Хичээл 4	Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам	1	1	2	

15.	Хичээл 5	Агуулахын аж ахуй мөрдөх дүрэм, журам	1	1	2
16.	Хичээл 6	Үйлдвэр-техникийн бараа материалыг хадгалах онцлог, мөрдөх дүрэм, журам	1	1	2
17.	Хичээл 7	Өвс тэжээл, улаан буудай хадгалах онцлог, мөрдөх дүрэм, журам	1	1	2
18.	8 песьих	Газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах үеийн технологийн үйл ажиллагаа, мөрдөх дүрэм журам	1	1	2
19.	Хичээл 9	Улсын нөөцийн бараа, материал хүлээн авах, хадгалах, зарцуулах, тооллого явуулах дотоод журам	1	1	2
20.	Хичээл 10	Улсын нөөцийн шатахууны агуулах, шатахуун сэлгэх станцад ээлж хүлээлцэх, тооллого хийх, тооцоо бодох журам	1	1	2
		10	10	20	
		Сэдэв 3. Эрх зүйн баримт бичиг			
21.	Хичээл 1	Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, мэдээ тайлан	1	1	1
22.	Хичээл 2	Бараа материалыг хүлээн авах, хадгалах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар	1	1	1
23.	Хичээл 3	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын өөрчлөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйл, урьдчилан сэргийлэх арга зам	1	1	1
24.	Хичээл 4	Бараа материал хадгалахад агуулах, сав, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах асуудал	1	1	1
25.	Хичээл 5	Нөөцийн бараа материалын бүртгэл хөтлөлт /агуулахын, нярав, сахиул, технологич/	1	1	1
		Нийт цаг	5	5	5
		Сэдэв 3. Эрүүл ахуй, хөдөлмөр хамгаал			
26.	Хичээл 1	Эмнэлгийн анхан шатны тусламж	1		1
27.	Хичээл 2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	2		2
		8		8	
		33	25	58	

ГЭРЭЭТ АЖИЛЧДЫН ӨӨЛӨТӨХ ИЙИЛСЕРИХ

д/д		n.i	Явуулах хэлбэр, цаг			
	Хичээлийн нэр	Лекц	Бие даалт	Бүх цаг		
		Сэдэв 1. Хууль, эрх зүй			•	
1.	Хичээл 1	Хөдөлмөрийн тухай хууль	1	1	2	
	Хичээл 2	Гамшгаас хамгаалах тухай хууль	1	1	2	
2.	Хичээл 3	Галын аюулгүй байдлын тухай хууль	1	1	2	
3.	Хичээл 4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	1	1	2	
4.	Хичээл 5	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай	1	1	2	
Нийт цаг			5	5	10	
		Сэдэв 2. Дүрэм журам				
5.	Хичээл 1	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын дүрмүүд	1	1	2	
6.	Хичээл 2	Харуул хамгаалалтын ажилтны эрх, үүрэг	1	1	2	

			13	13	26
Нийт цаг			3	3	6
12.	Хичээл 2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	2	2	4
11.	Хичээл 1	Эмнэлгийн анхан шатны тусламж	1	1	2
		Сэдэв 3. Эрүүл ахуй, хөдөлмөр хамгаал	ал		
		Нийт цаг	6	6	12
10.	8 песьих	Гал унтраах багаж хэрэгслийг ашиглах арга	1	1	2
9.	Хичээл 5	Объектод үзлэг явуулах тухай	1	1	2
8.	Хичээл 4	Холбоо мэдээллийн хэрэгслийг ашиглах	1	1	2
7.	Хичээл 3	Харуул хамгаалалтын ажилтан галт зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглах	1	1	2

41.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны Д дугаар сарын З-ны өдрийн МЭЗ дүгээр тушаалын гуравдугаар хавсралт

БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах, алба хаагчдад мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх, тэднийг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах, сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмаар зохицуулна.

- 1.2. "Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл" гэж Онцгой байдлын байгууллагад хуулиар хүлээсэн "Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх" үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг бие бүрэлдэхүүнд эзэмшүүлэх, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдал, жигдрэлтийг хангахад чиглэгдсэн зохион байгуулалттай, тодорхой зорилго, чиглэл бүхий цогц үйл ажиллагааг хэлнэ.
- 1.3.Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл нь /цаашид "сургалт бэлтгэл" гэх/ төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын албаны бэлтгэл, гамшгийн нөхцөлд гүйцэтгэх бэлэн байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн.
 - 1.4.Сургалт бэлтгэлийг дараах зарчимд тулгуурлан явуулна. Үүнд:
 - -Шинжлэх ухааны үндэстэй байх,
 - -Тодорхой зорилго чиглэлтэй байх,
- -Гамшгаас хамгаалах үндсэн үүргийг биелүүлэхэд шаардлагатай бүхэнд сургах,
 - -Үүсч болзошгүй гамшгийн цагийн байдалд ойртуулсан байх,
- -Суралцагчдын ухамсартай, санаачилгатай, бүтээлч, бие даасан байдалд тулгуурлах,
 - -Дэс дараалалтай, иж бүрэн (цогцолбор), хөнгөнөөс хүнд рүү шилжиж байх,
 - -Идэвхтэй, тасралтгүй, оновчтой байх,
 - -Нийт алба хаагчдад хүртээмжтэй байх,
 - -Ёс зүй, хүмүүжлийн нөлөөтэй байх,
 - -Байнга шинэчлэгдэж боловсрогдож байх.

Хоёр. Сургалт бэлтгэлийн тогтолцоо

2.1. Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн тогтолцоо нь албан ба албан бус сургалтын нэгдэл байх бөгөөд алба хаагчдыг ажлын байр мэргэшүүлэх болон давтан сургах, хөгжүүлэх гэсэн үндсэн төрлүүдээс бүрдэнэ.

- 2.2. Албаны сургалт бэлтгэлийг бүтэц, хамрах хүрээ, зориулалт, үе шатаар нь ангилна.
- -Бүтцээр нь: хүн нэг бүрийн, анги салбарын, газар, хэлтсийн, штабын бэлтгэл,
- **-Хамрах хүрээгээр нь**: дагнасан (газар, хэлтэс, анги, байгууллагын), хамтарсан, нэгдсэн,
- -**Зориулалтаар нь:** албаны бэлтгэл, гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл (олон талт үүргийн бэлтгэл),
 - -Ye шатаар нь: сургуулийн жилийн эхний хагас -I үе, сүүлийн хагас -II үе.
- 2.3.Хүн нэг бүрийн бэлтгэлийг **бүтцээр нь**: офицерын, ахлагчийн, *сургалтын хэлбэрээр нь*: онолын, дадлагын, бие даалтын гэж ангилна.
- 2.4. **Анги салбар, газар, хэлтсийн бэлтгэл нь** алба хаагчдын багаар ажиллах ур чадвар, гар нийлэмжтэй ажиллагааг дээшлүүлэх, анги, байгууллага, салбарын жигдрэлт, харилцан ажиллагааг хангахад чиглэгдэнэ.
- 2.5. **Штабын бэлтгэлээр:** Онцгой байдлын удирдах албан тушаалтны үйл ажиллагааг штабын албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх, сургалт бэлтгэлийн түвшин дээшлүүлэх, гамшгийн нөхцөл байдалд нийцсэн хамгийн оновчтой шийдвэрийг богино хугацаанд боловсруулж, бүтээлчээр хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлнэ.
- 2.5.1. Штабын дадлага, команд штабын сургууль, иж бүрэн сургуулийг гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл болон олон талт үүргийн бэлтгэлийг хангахад чиглүүлж, "Ослын удирдлагын систем" /Гэнэтийн ослын удирдлагын систем/-ээр том хэмжээний болон хавсарсан осол, гамшиг болон урьдчилан төлөвлөгдөөгүй үйл ажиллагаануудыг удирдах, зохион байгуулах үйл ажиллагаанд дадлагажуулахад чиглүүлэн зохион байгуулна.
- 2.5.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад штабын бэлтгэлийг дарга, захирагч удирдаж, газрын орлогч, штабын дарга төлөвлөж, зохион байгуулна.
- 2.6.Офицер, ахлагч нарын сургалт нь тэдэнд албан тушаалын үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ, томилгоот үүргийг гүйцэтгэх, бие биеэ орлон ажиллах, нэг шат дээгүүр албан тушаалын үүргийг хариуцан биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэх ба албан тушаал, ажилласан жил, боловсролын түшингээр нь ялгавартай зохион байгуулна.
- 2.7.Албаны бэлтгэлээр "Гамшгаас хамгаалах тухай" Монгол Улсын хуулиар хүлээсэн үндсэн үүргийг гамшгийн ямарч нөхцөл байдлын үед амжилттай биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, дадлага, ур чадварыг эзэмшүүлж, анги, байгууллага, салбарын жигдрэлт, харилцан ажиллагааг хангана.
- 2.8.Гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл болон олон талт үүргийн бэлтгэл нь Гамшгаас хамгаалах тухай болон Батлан хамгаалах бусад хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үндсэн үүрэг, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажиллах бэлтгэл, бэлэн байдлыг хангахад чиглэгдэнэ.
- 2.9. Онцгой байдлын байгууллагын сургуулийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Сургуулийн жилийн эхний хагас -I үе нь 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 5 дугаар

сарын 15-ны өдрийг хүртэл, сүүлийн хагас –II үе нь 9 дүгээр сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацааг тус тус хамарна.

- 2.10.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, гэрээт ажилтан албан хаагчид 7 хоног бүр 1 өдөр хичээллэнэ. Нэг өдрийн хичээлийн үргэлжлэх хугацаа 6 цаг, 1 цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байна.
- 2.11. Заах арга зүйн сургалтыг офицер, ахлагч сургагч багш нарт сургалтын онол, заах арга зүй, сургалт бэлтгэлийн зохион байгуулалт, сургалтыг удирдаж явуулах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сурган зааварлах, үзүүлэх болон нээлттэй хичээл, зааварчилга өгөх аргаар жил бүр зохион байгуулна. Удирдах бүрэлдэхүүний заах арга зүйн бэлтгэлийг сургуулийн жилийн өмнө Удирдах ажилтны цугларалтаар Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад заах арга зүйн бэлтгэлийг сургуулийн жилийн өмнө хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн (сургалт, соёл хүмүүжлийн алба, штабын дарга болон орлогч) зохион явуулна.
- 2.12. Албан бус сургалт гэж өдрөөр болон эчнээгээр, зайны болон мэдээлэл холбооны технологид суурилсан /онлайн/ сургалтын уламжлалт ба шинэлэг арга хэлбэр, хэрэгслийг ашиглан өөрийгөө хөгжүүлэх цогц үйл ажиллагааг хэлнэ.
 - 2.12.1.Албан бус сургалтын агуулга, хамрах хүрээ нь алба хаагчийн мэдлэг мэргэжил, боловсролоо дээшлүүлэх, амьдрах чадвараа хадгалах, бие даан хөгжүүлэхэд чиглэгдсэн байна.
 - 2.12.2.Алба хаагчийг Захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж нь төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гаргасан шийдвэрийг үндэслэн албан бус сургалтад хамруулна. Тухайн алба хаагчийн эзэмшсэн мэдлэг, суралцсан цаг, хангасан хөтөлбөр, мэргэжлийг гэрчилсэн баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх, диплом/-г үндэслэн албан бус сургалтын үр дүнг тооцно.

Гурав. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн менежмент

- 3.1. Сургалт бэлтгэлийн менежмент гэж бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн талаар дэвшүүлсэн зорилт, тушаал, шийдвэрийн заалтуудыг биелүүлж, анги, байгууллага нь албаны болон болзошгүй гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийг хангахын тулд бүх шатны удирдлага, штаб, албан тушаалтнаас сургалтын үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах, шаардагдах материал, санхүүгийн нөөцийг зохицуулах, хянах чиг үүргүүдийг хэрэгжүүлж буй удирдлагын шинжлэх ухаанч үйл ажиллагааг хэлнэ.
- 3.2. Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны стандартуудыг албаны үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд өөрийн онцлогт тохируулан сургалт, бэлтгэлийн хэлбэр тус бүрийн үйл явцын зураглалыг боловсруулж, түүний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын удирдлага, штабаас цэргийн сургалт бэлтгэлийг удирдахын тулд дараах авч хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- -Онцгой байдлын албаны сургалтын бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах,
- -Албаны болон болзошгүй гамшгийн цагийн байдлын үед болон гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах,
 - -Сургалт бэлтгэлийг төлөвлөж, зохион байгуулах тухай шийдвэр гаргах;
- -Сургалт бэлтгэлийг зохион байгуулах шийдвэр, төлөвлөгөөг бие бүрэлдэхүүнд цаг тухайд нь хүргэх,
- -Офицер, ахлагч сургагч багш нарын заах арга зүйн бэлтгэл, нийт бие бүрэлдэхүүний суралцах арга зүйг сайжруулах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх,
 - -Сургалт бэлтгэлийг тасралтгүй удирдлагаар хангах,
- -Зорилго зорилт, үүргүүдтэй уялдуулан сургалт бэлтгэлийн стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөнд тодотгол хийх,
- -Сургалт бэлтгэлийн тэргүүний арга, туршлагыг нэвтрүүлэх, сургалтын заах арга зүй, технологийг хөгжүүлэх,
- -Сургалт бэлтгэлийн орчин, материаллаг баазыг бэхжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглах,
- -Сургалт бэлтгэлийн зорилго, зорилт, стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөг чанартай биелүүлэхэд нийт бие бүрэлдэхүүний идэвх санаачилгыг өрнүүлж, тэдний бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх,
- -Сургалт бэлтгэлтэй уялдуулан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх замаар сургалтын агуулга, судлах зүйл, арга, технологийг боловсронгуй болгох,
- -Сургуулийн жилийн үе бүрийн зорилт, үүргийн биелэлтийг тодорхой дүгнэж, шинэ зорилтыг дэвшүүлэх, бий болсон саад, бэрхшээл, дутагдлыг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах.
- 3.4.Сургалт бэлтгэлийн менежментийг хэрэгжүүлэхийн тулд Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын удирдлага, штабаас дараах баримт бичгүүдийг боловсруулж мөрдөнө.
- 3.4.1.Удирдлагын баримт бичиг: Монгол Улсын хууль, тогтоомж, Шадар сайдын тушаал, шийдвэрийн холбогдох хэсэг, Онцгой байдлын албаны сургалтын бодлого, хөтөлбөр, энэхүү журам, сургуулийн жилийн удирдамж, сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар, сургалт бэлтгэлд хийх хяналт, шалгалтын ажлын удирдамж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай тушаал, сургалт бэлтгэлийн стандарт, сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, хичээл, сургууль, дадлагыг зохион байгуулах тухай удирдамж, заавар, журам, төлөвлөгөө, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх төлөвлөгөө зэрэг сургалт бэлтгэлийг төлөвлөх, суралцагчдад үүрэг хүргэх ба түүний биелэлтийг шалгахад зориулагдсан баримт бичгүүд,
- 3.4.2.Тайлан-мэдээллийн баримт бичиг: хичээлийн хөтөлбөр, хуваарь, төлөвлөгөө, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын шалгалтын нотломж, улирал, хагас жилийн сургалтын мэдээ, хичээлийн бүртгэл, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх тооцоо, төлөвлөгөө, сургалт бэлтгэлийн төлөвлөлтийн хэрэгжилт, үр дүнгийн талаар хийх илтгэл, тайлан мэдээ, сургалт бэлтгэлийн ололт амжилтыг дэлгэрүүлэхэд чиглэгдсэн баримт бичгүүд,

- 3.4.3. Лавлах баримт бичиг- цагийн ерөнхий тооцоо, хичээл бүрийн цагийн тооцоо, хичээл, сургууль, дадлагыг явуулахад ашиглах төрөл бүрийн лавлах материал /техник, багаж хэрэгслийн тактик техникийн өгөгдөхүүн/, бүдүүвч, тооцоо, хүснэгт, шалгуур үзүүлэлт зэрэг сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдаж явуулах үед ашиглах баримт бичиг,
- 3.5. Сургуулийн жилийн удирдамжийг тухайн сургуулийн жил эхлэхээс 14 хоногийн өмнө Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлага хариуцсан бүтцийн нэгж боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ.
- 3.6. Онцгой байдлын байгууллагын сургалтын хөтөлбөр, энэхүү журам, сургуулийн жилийн удирдамжийг үндэслэн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах дарга, захирагчийн тушаал, шийдвэр, сургуулийн жилийн удирдамж, сургалт, бэлтгэлийн төлөвлөгөө, хичээлийн хуваарь гарган хэрэгжилтийг зохион байгуулна.
- 3.7. Сургалт бэлтгэл нь бие бүрэлдэхүүний болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хүрэх түвшин, хичээлийн агуулга, түүний үнэлгээ, сургалтад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлсон стандарттай байна.
- 3.8. Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн удирдлага зохион байгуулалтыг дараах байдлаар зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.8.1. Онцгой байдлын ерөнхий газар нь албаны болон болзошгүй гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшин дээшлүүлэх бодлого, зорилтыг тодорхойлж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын албаны бэлэн байдлыг хангах, оперативын түвшний хамтарсан болон нэгдсэн команд штабын сургууль, штабын дадлага, сургуулийг мэргэжлийн удирдлагаар хангана.
- 3.8.2. Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын асуудал хариуцсан бүтцийн нэгж бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлт, удирдлага, зохицуулалтын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудын сургалт бэлтгэлийн явц, үр дүнг хянаж, мэргэжлийн удирдлагаар хангана.
- 3.8.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар нь сургалт бэлтгэлийн агуулга, арга зүй, технологийг боловсронгуй болгох, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хариуцаж, сургуулийн жилийн удирдамжийн биелэлт, сургалт бэлтгэлийг зохион байгуулсан тайлан, мэдээ, дүнг сургуулийн жилийн үе бүрийн төгсгөлд болон жилийн эцэст Захиргааны удирдлагын асуудал хариуцсан бүтцийн нэгжээр дамжуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулна.
- 3.8.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн нь сургалт бэлтгэлийг төлөвлөх, зохион байгуулах, удирдан явуулах, хянах чиг үүргийг хариуцан хэрэгжүүлж, өөрийн салбар, нэгжүүдийн албаны болон гамшгийн үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлын үр дүнг хариуцна.
- 3.8.5.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн нь албан тушаалтнуудыг

мэргэшүүлэх, бие бүрэлдэхүүний сургалтын арга зүйг боловсронгуй болгох, сургалт бэлтгэлд тэргүүний арга, технологи, туршлагыг нэвтрүүлэх, хичээлүүдийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн конспект-төлөвлөгөөг хянаж, удирдлагад танилцуулан баталгаажуулах, хэрэгжүүлэх, тайлагнана.

- 3.8.6.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын офицерууд нь хариуцсан бие бүрэлдэхүүнийхээ тусгай /мэргэжлийн/ бэлтгэлийг удирдан явуулж, хичээл заана.
- 3.8.7.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг цэргийн алба, соёл хүмүүжлийн ажилтай нягт уялдуулан зохион байгуулна.
- 3.9.Энэхүү журамд заагдаагүй сургалт бэлтгэлтэй холбогдсон бусад асуудлуудыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарын тушаал, шийдвэрээр зохицуулна.

Дөрөв. Сургалт бэлтгэлийн үр дүнг тооцох

- 4.1. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд "Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар"-ын дагуу шалгалт, шалган туслах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцно.
- 4.2. Бие бүрэлдэхүүний болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, нэгжийн сургалтын ерөнхий дүн нь тухайн алба хаагчийн болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, нэгжийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэх үндсэн үзүүлэлтийн нэг шалгуур нь байна.
- 4.3. Сургалт бэлтгэлийн дүнгээр "В", түүнээс дээш үнэлгээтэй суралцсан алба хаагч, хариуцсан анги, байгууллага, нэгж нь "В" түүнээс дээш үнэлгээтэй шалгагдсан офицер, ахлагч нарыг сургууль, дамжаанд суралцуулах, олон улсын аврах ажиллагаа, Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Энхийг дэмжих ажиллагаа" болон олон улсын сургалт, дадлагад оролцуулах асуудлыг хамгийн түрүүнд авч хэлэлцэнэ.
- 4.4. Онцгой байдлын ерөнхий газрын сургуулийн жилийн төгсгөлийн болон мэргэжлийн түвшин тогтоох шалгалт, тус газрын даргын нэрэмжит болон хяналтын шалгалтаар өөрөө эсвэл хариуцсан анги, байгууллага, нэгж нь "Хангалтгүй" үнэлгээтэй шалгагдсан бол тухайн офицер, ахлагчийг албан тушаал бууруулах, цэргийн албанаас халах үндэслэл болно.
- 4.5. Офицер, ахлагч нарын сургалт бэлтгэлийн стандартын шаардлагыг хангаж, өөрийгөө хөгжүүлж буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор албан хаагч бүрт сургалт бэлтгэл, мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний дэвтэр /цахимаар байж болно/ хөтөлнө.

47.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны Дугаар сарын Оны өдрийн А ЗОХ дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт

БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ, БЭЛТГЭЛИЙГ ШАЛГАЖ ҮНЭЛЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврыг бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийх шалгалтын төрөл, тавигдах шаардлага, шалгаж үнэлэх үндсэн чиглэл, хүн нэг бүрийн албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадварын түвшинг шалгаж үнэлэх арга, хэлбэрийг тодорхойлоход мөрдөн ажиллана.

1.2. Онцгой байдлын ерөнхий газрын шалгалтыг тус газрын даргын нэрэмжит болон хяналтын, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын

шалгалтыг сургуулийн жилийн I үеийн, төгсгөлийн гэж ангилна.

1.3. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн шалгалтыг албаны бэлтгэл бэлэн байдлын болон харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт, шалгалтаас тусад нь бие даасан байдлаар зохион байгуулна.

1.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын сургалт бэлтгэлийг

шалгаж, үнэлэхэд тавигдах шаардлага:

-Өөрийн гүйцэтгэх үүрэг, бүтэц зохион байгуулалтад бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн хөтөлбөр, стандартыг уялдуулсан байх,

-Бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадвар, сургалт бэлтгэлээр хүрсэн байх түвшин, салбаруудын албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийг шалгаж үнэлэхэд чиглэгдсэн байх,

-Шалгалтын арга, хэлбэр, түүнд бэлтгэх нөхцөл боломж, хугацааг сургалтын хөтөлбөрийн үндсэн агуулга, бие бүрэлдэхүүнийг сургах, суралцах арга зүйн талаас нь нарийн тооцож, боловсруулсан байх.

1.5.Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх үндсэн чиглэл:

-Бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадвар, бие бялдрын бэлтгэлийн түвшин

-Албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшин,

-Сургалт бэлтгэлийн хөтөлбөр, төлөвлөгөө, сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.

1.6. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтад бие бүрэлдэхүүний 90-ээс доошгүй хувийг, хяналтын буюу удирдамжийн шалгалтад 60-аас доошгүй хувийг хамруулна.

1.7. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон сургуулийн жилийн төгсгөлийн, хяналтын шалгалтыг тухайн анги, байгууллагын бие бүрэлдэхүүний жагсаалын үзлэгээр эхэлж, нэгдсэн дүнгийн хурлаар дуусгана.

Хоёр. Онцгой байдлын ерөнхий бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийх шалгалт

2.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон хяналтын шалгалтын зорилго нь бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадвар, үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшинг тодорхойлох, Онцгой байдлын ерөнхий газар болон байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан ажил, сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилт, стандартын хэрэгжилтэд

үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

2.2. Онцгой байдлын ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөг үндэслэн бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийх шалгалтын ажлыг зохион байгуулж явуулна.

2.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит шалгалтыг 2-3 жилд, хяналтын шалгалтыг сургуулийн жилд 1 удаа тус газрын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг удирдамжийн дагуу явуулна.

2.4. Онцгой байдлын ерөнхий газрын хяналтын шалгалтаар шалган туслах

ажлыг явуулж, мэргэжлийн удирдлага, заавар зөвлөмж өгч ажиллана.

Гурав. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын удирдлагаас бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийх шалгалт

3.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын удирдлага бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд тухайн жилийн сургуулийн жилийн удирдамж,

энэхүү зааврыг үндэслэн хяналт, шалгалтыг зохион байгуулж явуулна.

3.2. Сургуулийн жилийн үе бүрийн төгсгөлд бие бүрэлдэхүүний мэдлэг, чадварын хүрсэн байх түвшин, албаны болон гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшинг тогтоох, сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилт, биелэлтийг тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийж, цаашдын чиглэл, авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, зөвлөмж гаргах зорилгоор зохион байгуулна.

3.3. Сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтыг бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадвар, үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшинг тодорхойлох, сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилт, стандартын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор дарга,

захирагчийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг явуулна.

Дөрөв. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж, өгөх үнэлгээ

4.1. Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг:

-Офицеруудын сургалт бэлтгэл,

-Ахлагч нарын сургалт бэлтгэлийг үнэлж, нэгжийн ерөнхий үнэлгээгээр дугнэнэ.

4.2. Офицеруудын бүрэлдэхүүнээс:

-Биеийн тамирын бэлтгэл /Бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтээр, насны ангиллаар/

-Цэргийн хэрэг, жагсаалын бэлтгэл /онолоор болон жагсаалыг биеэр

гүйцэтгэх, жагсаал удирдах ур чадвар/,

-Онолын мэдлэг /гамшгийн менежмент, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, эрх зүйн үндэс, эрүүл мэнд-сэтгэл зүйн, ёс зүйн хүмүүжил, гадаад хэл/ гэсэн 5 төрлийн хичээлүүдээс сонгон тестийн болон асуумжийн шалгалт авч, унэлгээ өгнө.

4.3. Ахлагч бүрэлдэхүүнээс:

-Биеийн тамирын бэлтгэл /Бие бялдрын бэлтгэлжилтийн үзүүлэлтээр, насны ангиллаар/,

-Цэргийн хэрэг, жагсаалын бэлтгэл /онолоор болон жагсаалыг биеэр гүйцэтгэх/,

-Онолын мэдлэг /Тусгай бэлтгэл, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, эрх зүйн үндэс, эрүүл мэнд-сэтгэл зүй, ёс зүйн хүмүүжил, гадаад хэл/ гэсэн 5 төрлийн хичээлүүдээс сонгон тестийн болон асуумжийн шалгалт авч, үнэлгээ өгнө.

4.4. Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг тоон болон үсгэн үнэлгээгээр

дараах байдлаар дүгнэнэ.

-90-100 оноо А буюу "Маш сайн" үнэлгээ,

-80-89 оноо В буюу "Сайн" үнэлгээ.

-70-79 оноо С буюу "Хангалттай" үнэлгээ,

-60-69 оноо D буюу "Дутагдалтай" үнэлгээ,

-50-59 оноо F буюу "Хангалтгүй" үнэлгээ бөгөөд дараах утгыг илэрхийлнэ.

"А"-Мэдлэг, дадлага, ур чадварын түвшний дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн сэдэв, агуулгыг бүрэн ойлгосон, цэргийн хэргийн өргөн мэдлэгтэй, эзэмшсэн мэдлэгээ шаардлагатай үед хэрэглэх дадлага, ур чадварыг бүрэн эзэмшсэн, бие бялдрын бэлтгэлжилт шаардлагын түшингээс өндөр болохыг илэрхийлнэ.

"В"-Мэдлэг, дадлага, ур чадварын түвшин нь дундаж түшингээс дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн сэдэв, агуулгыг сайн ойлгосон боловч практикт хэрэглэх үедээ бага зэрэг алдаа гаргасан, цэргийн хэргийн тодорхой мэдлэгтэй, бие бялдрын бэлтгэлжилт шаардлагын түвшинд байгаа болохыг илэрхийлнэ.

"С"-Мэдлэг, дадлага, ур чадварын түвшин нь дундаж амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн сэдэв, агуулгыг дундаж түвшинд ойлгосон, эзэмшсэн мэдлэгээ хэрэглэхдээ алдаа, дутагдал гаргасан, бие бялдрын бэлтгэлжилт шаардлагын түвшингээс бага болохыг илэрхийлнэ.

"D"-Мэдлэг, дадлага, ур чадварын түвшин дундаж түвшингээс доогуур амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн сэдэв, агуулгыг дутуу ойлгосон, эзэмшсэн мэдлэгээ шаардлагатай үед хэрэглэх дадлага, чадвар дутмаг, бие бялдрын бэлтгэлжилт шаардлагын түвшингээс нэлээд доогуур болохыг илэрхийлнэ.

"F"- Мэдлэг, дадлага, ур чадварын түвшин нь хангалтгүй болохыг илтгэх дүн. Тухайн хичээлийн сэдэв, агуулгыг ойлгоогүй, эзэмшсэн мэдлэгээ шаардлагатай үед хэрэглэх дадлага, чадвар эзэмшээгүй, бие бялдрын бэлтгэлжилт шаардлагын түвшинг хангахгүй байгааг илэрхийлнэ.

4.5.Хүн нэг бүрийг "Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журам"-д заасан хичээлүүдээс сонгон тухайн сургуулийн жилд сургалт бэлтгэлийн стандартаар эзэмшвэл зохих агуулгын хүрээнд шалгаж, тоон болон үсгэн үнэлгээгээр дүгнэнэ. Хичээл тус бүрийн тоон дүнгийн нийлбэрийг тухайн шалгалтад хамрагдсан хичээлийн тоонд харьцуулан хүн нэг бүрийн ерөнхий үнэлгээг гаргана.

4.6.Хичээлийг үнэлэхдээ шалгагдсан хүн тус бүрийн тоон дүнгийн нийлбэрийг тухайн шалгалтад хамрагдсан хүний тоонд харьцуулан хичээлийн ерөнхий үнэлгээг гаргана.

4.7.Тухайн алба хаагчийн сурлагын ерөнхий дүнг гаргахын тулд шалгагдсан хичээл тус бүрт авсан тоон үнэлгээнүүдийг нэмж, хичээлийн тоонд хувааж гаргах бөгөөд сурлагын амжилт, чанарыг хувилж гаргана.

Тав. Шалгалтын арга, хэлбэр

5.1. Хүн нэг бүрийн мэдлэг, дадлага, чадварыг онолоор болон дадлагаар, аман, бичгийн, гүйцэтгэх гэсэн шалгалтын хэлбэрийн аль нэгээр, эсвэл тэдгээрийн хосолсон хэлбэрээр шалгаж үнэлнэ.

5.2. Онолын мэдлэгийг аман болон бичгийн шалгалтыг сонгосон асуултад амаар болон бичгээр хариулт өгөх, тест бөглөх аргаар авна.

5.3. Гүйцэтгэх шалгалтыг өгөгдсөн цагийн байдлыг богино хугацаанд боловсруулж зурагт оруулан шийдвэр гаргах, бие бялдрын бэлтгэлжилт, тусгай бэлтгэл хичээлийн мэргэжлийн норматив, жолоодлого үйлдэх зэрэг аргаар авна.

5.4. Жагсаалын бэлтгэлийн биеэр гүйцэтгүүлэх шалгалтаар хүн нэг бүрийг үнэлж дүгнэхдээ ганцаарчилсан болон салаа, бүлгээр ажиллуулан шалгаж болно.

5.5. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгийн нөхцөл байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшинг штабын дадлага,

команд штабын сургуулиар тодорхой цагийн байдалд үүрэг гүйцэтгэх аргаар шалгана.

Зургаа. Шалгалтын нотломж бичих, дүн гаргах

6.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон хяналтын шалгалтын дүнгийн талаар шалгалт дууссанаас хойш 7 хоногийн дотор нотломж бичиж, даргаар батлуулан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ.

6.2. Шалгалтын нотломжид дараах үндсэн асуудлуудыг тусгана. Үүнд:

-Шалгалтын зохион байгуулалт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, онцлог, шалгалт авсан хичээлүүдийн дүн, алба хаагч бүр болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын сургалтын амжилт, түүнд хийсэн үнэлэлт, дүгнэлт,

-Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын албаны болон

гамшгийн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл, жигдрэлтийн түвшин,

-Сургуулийн жилийн зорилго, зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөний

хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн,

-Сургалтын орчин нөхцөл, материаллаг баазыг бэхжүүлэх талаар хийсэн ажил, сургалт бэлтгэлээр олсон амжилт, нэвтрүүлсэн тэргүүн туршлага, менежмент, гаргасан алдаа, дутагдал, түүний шалтгаан,

-Сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлсэн байдлыг сургуулийн жилийн I үеийн болон төгсгөлийн үр дүнтэй харьцуулж, дутагдлыг арилгах арга зам, цаашид Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг тусгана.

6.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудад явагдсан Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон хяналтын шалгалтын дүнг нэгтгэн Даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар баталгаажуулна.

6.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн шалгалтын дүнг нэгтгэн, шалгалтыг явуулснаас хойш 14

хоногийн дотор Захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

6.5. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлд хийсэн хяналт шалгалтын үр дүн, сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, стандартын хэрэгжилтэд Дотоод хяналт шалгалтын асуудал хариуцсан бүтцийн нэгж хяналт, шинжилгээ хийнэ.

Долоо. Шагнал, урамшуулал, хүлээх хариуцлага

- 7.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит болон хяналтын шалгалтаар "А", "В" үнэлгээ авсан алба хаагч, албан тушаалтны шагнаж урамшуулах саналыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч уламжлах;
- 7.2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит шалгалтаар "А" үнэлгээ авсан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагыг "Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлээр манлайлагч, тэргүүлэгч байгууллага" гэрчилгээг тухайн оны сүүлээр тайлангийн хуралд гардуулна.
- 7.3. Шалгалтад "D", "F" үнэлгээ авсан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын удирдлагад Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар хариуцлага тооцож, сургалт бэлтгэлийн ажлыг сайжруулах 3, 6 сарын хугацаатай үүрэг өгч, дахин ажлын хэсэг томилж шалгана.